

Translated from Mongolian to English
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
16 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт
Annex 4 to the Resolution №16
of the Board of Directors dated 18th March 2025.
Sealed by the stamp /Mongolian Stock Exchange/

**ЗЭСИЙН БАЯЖМАЛЫН АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ
СТАНДАРТ ТОГТООХ, МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ
REGULATION FOR ESTABLISHING AND IMPLEMENTING STANDARD OF THE COPPER
CONCENTRATE TRADING AGREEMENT**



**ЗЭСИЙН БАЯЖМАЛЫН ГЭРЭЭНИЙ СТАНДАРТ ТОГТООХ,
МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ**

**REGULATION FOR ESTABLISHING AND IMPLEMENTING STANDARD OF THE COPPER
CONCENTRATE TRADING AGREEMENT**

Нэг.Ерөнхий үндэслэл/ One. General Provisions	2
Хоёр.Арилжааны гэрээнд тавигдах шаардлага/ Two. Requirements for the Trading Agreement.....	2
Гурав. Арилжааны гэрээг байгуулсанд тооцох, биржид бүртгүүлэх/ Three. Consideration of the Agreement as Concluded and Registration with the Exchange	3
Дөрөв.Арилжааны гэрээний төлбөр, тооцоо/ Four. Payment and Settlement of the Trading Agreement	4
Тав.Арилжааны гэрээний хэрэгжилт, түүнд тавих хяналт/ Five. Implementation of the Trading Agreement and Related Oversight.....	4
Зургаа.Арилжааны гэрээг дуусгавар болгох, түүний үр дагавар/ Six. Termination of the Trading Agreement and Its Consequences.....	5
Долоо.Тээвэрлэлт, хадгалалт, чанарын хяналт/ Seven. Transportation, Storage, and Quality Control	6
<i>Тээвэр логистик/ Transport Logistics</i>	<i>6</i>
<i>Агуулахын баримт, хадгалалт/ Warehouse Documentation, Storage</i>	<i>7</i>
<i>Чанарын хяналт/ Quality Control</i>	<i>8</i>
Найм.Бусад/ Eight. Miscellaneous	10

Зэсийн баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
Regulation For Establishing And Implementing Standard Of The
Copper Concentrate Trading Agreement



Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
16 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт
Annex 4 to the Resolution №16
of the Board of Directors dated 18th March 2025.

**ЗЭСИЙН БАЯЖМАЛЫН АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ
СТАНДАРТ ТОГТООХ, МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ**
**REGULATION FOR ESTABLISHING AND IMPLEMENTING STANDARD OF THE COPPER
CONCENTRATE TRADING AGREEMENT**

Нэг.Ерөнхий үндэслэл
One. General Provisions

- 1.1. Энэхүү журмаар “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-иар арилжаалсан зэсийн баяжмалын арилжааны гэрээний стандартыг тогтоох, хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.1. This Regulation governs the relations pertaining to the establishment of standard for the trading agreement of copper concentrate traded through the “Mongolian Stock Exchange” JSC (hereinafter referred to as the “Exchange”) and the monitoring of its implementation.
- 1.2. Энэхүү журамд заасан үйл ажиллагаа нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) болон Биржээс баталсан журам, заавар, түүнд нийцүүлэн гаргасан бусад шийдвэрийн хүрээнд хэрэгжинэ.
- 1.2. The activities specified in this Regulation shall be implemented within the framework of the Law of Mongolia on Mining Products Exchange, other relevant laws, resolutions, and rules, guidelines approved by the Financial Regulatory Commission (hereinafter referred to as the “Commission”) and the Exchange.
- 1.3. Энэхүү журмыг Биржийн арилжаанд оролцогчид, Биржийн зах зээлийн бусад оролцогчид дагаж мөрдөнө.
- 1.3. This Regulation shall be followed by participants in the Exchange’s trading as well as other market participants of the Exchange.

Хоёр.Арилжааны гэрээнд тавигдах шаардлага
Two. Requirements for the Trading Agreement

- 2.1. Гэрээгээр арилжаалах зэсийн баяжмалын 1 багц нь 1000 тонн (нойтон метр тонн) байна.
- 2.1. One lot of copper concentrate to be traded under the agreement shall be 1,000 tons (wet metric ton).
- 2.2. Форвард гэрээний хугацаа 12 сар хүртэл хугацаатай байна.
- 2.2. The term of a forward agreement shall be up to 12 months.

Зэсийн баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
Regulation For Establishing And Implementing Standard Of The
Copper Concentrate Trading Agreement



- 2.3. Спот гэрээний хугацаа 30 буюу түүнээс доош хоногийн хугацаатай байна.
- 2.3. The term of a spot agreement shall be 30 days or less.
- 2.4. Гэрээний үнийг ам.доллараар илэрхийлэх ба “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-д заасны дагуу тогтооно.
- 2.4. The agreement price shall be expressed in USD and determined in accordance with the “Regulation on Exchange Trading of Mineral Commodities.”
- 2.5. Форвард гэрээний хувьд зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан гэрээний үнийг тохируулж болох бөгөөд үнийн тохируулгын нөхцөл, тооцох аргачлалыг тодорхой тусгана.
- 2.5. For forward agreement, the agreement price may be adjusted based on market conditions, and the terms and methodology for such price adjustment shall be clearly specified.
- 2.6. Арилжааны үед гэрээний үнийг тогтоохдоо худалдагч өөрөөр тогтоогоогүй тохиолдолд хамгийн багадаа тонн тутамд 5 ам.доллараар өсгөх замаар үнийг тогтоосон байна.
- 2.6. Unless otherwise specified by the seller during the trading session, the agreement price shall be increased by at least 5 USD per ton.
- 2.7. Гэрээний дуусгавар болох хугацаа бүтээгдэхүүн нийлүүлж дуусах хугацаанаас хэтрэхгүй байна.
- 2.7. The expiration date of the agreement shall not exceed the date by which the product delivery is completed.
- 2.8. Арилжааны гэрээ болон түүнтэй холбоотой бусад харилцаанд зөвхөн Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.
- 2.8. Only the laws of Mongolia shall apply to the trading agreement and other related legal relationships.

Гурав. Арилжааны гэрээг байгуулсанд тооцох, биржид бүртгүүлэх
Three. Consideration of the Agreement as Concluded and Registration with the Exchange

- 3.1. Уул уурхайн бүтээгдэхүүний цахим арилжаа амжилттай зохион байгуулагдаж, хэлцэл хийгдсэнээр арилжааны гэрээ байгуулагдсанд тооцож, Биржид бүртгэгдэнэ.
- 3.1. A trading agreement shall be deemed concluded and registered with the Exchange upon successful organization of the electronic trading of mineral commodities and execution of a Implied agreement.
- 3.2. Арилжааны гэрээг байгуулахдаа гэрээний хугацаа эхлэх өдрийг арилжааны системд хэлцэл амжилттай хийгдсэн өдрөөр тусгана.
- 3.2. When concluding the trading agreement, the start date of the agreement shall be recorded as the date on which the Implied agreement was successfully executed in the trading system.
- 3.3. Талууд арилжааны гэрээг хэлцэл биелснээс хойш ажлын 5 өдрийн дотор байгуулан

Зэсийн баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
 Regulation For Establishing And Implementing Standard Of The
 Copper Concentrate Trading Agreement

Биржид ирүүлэх үүрэгтэй. Гэрээг ирүүлээгүй нь гэрээний үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

- 3.3. The parties must conclude the trading agreement within 5 business days after the Implied agreement is executed and submit it to the Exchange. Failure to conclude and submit the agreement shall not serve as grounds for exemption from agreement obligations.
- 3.4. Талууд арилжааны гэрээг байгуулахдаа системд хийгдсэн хэлцлийн дагуу байгуулна.
- 3.4. The trading agreement shall be concluded in accordance with the terms of the Implied agreement executed in the system.
- 3.5. Талуудын байгуулсан арилжааны гэрээ болон түүний нэмэлт гэрээг тухай бүр Биржид бүртгүүлнэ.
- 3.5. The parties must register the concluded trading agreement and any amendments thereto with the Exchange as they occur.

Дөрөв.Арилжааны гэрээний төлбөр, тооцоо **Four. Payment and Settlement of the Trading Agreement**

- 4.1. Спот гэрээний нийт төлбөрийг худалдан авагч нь хэлцэл амжилттай хийгдсэнээс хойш ажлын 7 өдрийн дотор худалдагчийн дансанд шилжүүлнэ.
- 4.1. The total payment for the spot agreement shall be transferred by the bidder to the seller's account within 7 working days after the successful conclusion of the Implied Agreement.
- 4.2. Форвард гэрээний дагуу хүргэлт хийхээс ажлын 5 хоногийн өмнө худалдан авагч нь тухайн хүргэлтэд ногдох төлбөрийг худалдагчийн дансанд шилжүүлэх ба хүргэлттэй холбоотой нарийвчилсан харилцааг экспортын гэрээнд заасны дагуу зохицуулна.
- 4.2. Under the forward agreement, the bidder shall transfer the payment corresponding to the delivery to the seller's account no later than 5 business days before the scheduled delivery. Detailed arrangements related to the delivery shall be governed in accordance with the export agreement.
- 4.3. Арилжааны гэрээний төлбөр, тооцоо гүйцэтгэх бусад харилцааг “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам”-д заасны дагуу зохицуулна.
- 4.3. Other relations concerning the settlement of payments for the trading agreement shall be governed by the “Regulation on Exchange Trade Settlement of the Mineral Commodities.”

Тав.Арилжааны гэрээний хэрэгжилт, түүнд тавих хяналт **Five. Implementation of the Trading Agreement and Related Oversight**

- 5.1. Худалдагч эсхүл түүний брокер нь спот, форвард гэрээний хэрэгжилтийн талаарх тайланг Биржид сар бүрийн 10-ны өдөр шинэчлэн ирүүлнэ.
- 5.1. The seller or their broker shall submit updated report on the implementation of the spot and forward agreements to the Exchange on the 10th day of each month.

Зэсийн баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
Regulation For Establishing And Implementing Standard Of The
Copper Concentrate Trading Agreement

- 5.2. Энэхүү журмын 5.1-т заасан тайланд дараах мэдээллийг тусгасан байна.Үүнд:
- 5.2. The report specified in Clause 5.1 of this Regulation shall include the following information:
- 5.2.1. бүтээгдэхүүний төлбөр төлсөн баримт;
 - 5.2.1. Payment proof for the commodities;
 - 5.2.2. нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ;
 - 5.2.2. Quantity of the product supplied;
 - 5.2.3. тээвэрлэлтийн мэдээлэл;
 - 5.2.3. Transportation information;
- 5.3. Бирж нь арилжааны гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор худалдагч эсхүл түүний брокероос нэмэлт мэдээлэл шаардаж болно.
- 5.3. The Exchange may request additional information from the seller or their broker in order to monitor the implementation of the trading agreement.
- 5.4. Арилжааны гэрээний хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх, шинжилгээ хийлгэхдээ зөвхөн Биржийн итгэмжлэгдсэн этгээдээр гүйцэтгүүлнэ.
- 5.4. In connection with ensuring the implementation of the trading agreement, the storage, transportation, and testing of the commodities shall only be performed by entities authorized by the Exchange.

Зургаа.Арилжааны гэрээг дуусгавар болгох, түүний үр дагавар
Six. Termination of the Trading Agreement and Its Consequences

- 6.1. Арилжааны гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
- 6.1. The trading agreement shall be terminated under the following circumstances:
- 6.1.1. талууд гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор харилцан тохиролцсон;
 - 6.1.1. The parties have mutually agreed to terminate the agreement before its expiration;
 - 6.1.2. талууд арилжааны гэрээний үүргийг бүрэн биелүүлсэн;
 - 6.1.2. The parties have fully performed their obligations under the trading agreement;
 - 6.1.3. холбогдох хууль тогтоомж болон гэрээнд заасны дагуу гэрээ дуусгавар болох үндэслэл бий болсон.
 - 6.1.3. There is a legal basis for termination under the relevant laws and provisions of the agreement.
- 6.2. Гэрээг дуусгавар болгоход баримтлах нөхцөл
- 6.2. Provisions for termination of the agreement:
- 6.2.1. Худалдагч, худалдан авагч тал нь гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор харилцан тохиролцсон бол гэрээг дуусгавар болж байгаа үндэслэл,

шалтгаан болон дэнчинг гэрээний аль талд шилжүүлэх тухай акт үйлдэж, тус актыг Биржид ирүүлнэ.

6.2.1. If the seller and bidder agree to terminate the agreement prior to the expiration date, they shall prepare an act stating the grounds and reasons for termination, and which party the collateral shall be transferred to, and submit this act to the Exchange.

6.2.2. Талууд арилжааны гэрээний үүргийг бүрэн биелүүлсэн бол Биржийн “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам”-д заасан баримт бичгийг Биржид ирүүлнэ.

6.2.2. If the parties have fully performed their obligations under the trading agreement, they shall submit the documentation specified in the Exchange’s “Regulation on Exchange Trade Settlement of the Mineral Commodities” to the Exchange.

6.3. Гэрээг дуусгавар болгосон, хүчингүйд тооцсоны үр дагавар

6.3. Consequences of termination or invalidation of the agreement:

6.3.1. Гэрээг дуусгавар болгосон тохиолдолд арилжааны дэнчинтэй холбоотой харилцааг Биржийн “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам”-аар зохицуулна.

6.3.1. In the event of termination of the agreement, matters related to the trading collateral shall be regulated in accordance with the Exchange’s “Regulation on Exchange Trade Settlement of the Mineral Commodities”.

6.3.2. Арилжааны системд хийгдсэн арилжааны гэрээг талууд журамд заасан хугацаанд байгуулаагүй бол тухайн гэрээг цуцлах, дуусгавар болгохтой холбоотой харилцаанд 6.1, 6.2-т заасан зохицуулалт нэгэн адил хэрэглэгдэнэ.

6.3.2. If the trading agreement based on the Implied agreement executed in the trading system is not concluded within the prescribed period, the provisions of Clauses 6.1 and 6.2 shall apply to the termination or cancellation of the agreement.

Долоо.Тээвэрлэлт, хадгалалт, чанарын хяналт **Seven. Transportation, Storage, and Quality Control**

Тээвэр логистик

Transport Logistics

7.1. Бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн агуулах, терминалаас нийлүүлэх цэгт хүргэх ажиллагааг худалдагчтай гэрээ байгуулсан Биржийн итгэмжлэгдсэн тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгч гүйцэтгэнэ.

7.1. The delivery of the commodities from the certified warehouse or terminal to the delivery point shall be carried out by a transport logistics service provider authorized by the Exchange and concluded an agreement with the seller.

7.2. Худалдагч нь хүргэлт хийх тээврийн хэрэгслийн дугаар, хүргэлтийн маршрут,

Зэсийн баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
Regulation For Establishing And Implementing Standard Of The
Copper Concentrate Trading Agreement

бүтээгдэхүүн, тоо хэмжээ, очих хугацааны талаар мэдээллийг итгэмжлэгдсэн агуулах, терминалд бүтээгдэхүүнийг хүргэхээс 3 хоногийн өмнө мэдэгдэнэ.

- 7.2. The Seller shall notify the authorized warehouse or terminal of the transport vehicle number, delivery route, commodity, quantity, and estimated time of arrival no later than 3 days before delivering the commodity.
- 7.3. Худалдан авагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол Худалдагч нь бүтээгдэхүүний гэрээнд заасан газарт хүргэх хүртэл хугацааны тээвэрлэлтийн эрсдэлийг хариуцна.
- 7.3. Unless otherwise specified in the agreement with the Bidder, the Seller shall bear the transportation risks until the commodity is delivered to the location specified in the agreement.
- 7.4. Тээвэр логиستيкийн үйл ажиллагаа эрхлэгч нь тээвэрлэлтийн гэрээ байгуулсан этгээдийн өмнө хариуцлага хүлээнэ.
- 7.4. The logistics service provider shall be liable to the party with whom it has concluded the transportation agreement.
- 7.5. Худалдан авагч Биржийн итгэмжлэгдсэн тээвэр логиستيкийн үйл ажиллагаа эрхлэгчийг ашиглахгүйгээр бүтээгдэхүүнийг хүлээн авах бол ачилт хийгдсэнээр хүргэлтийн үйл ажиллагаа дууссан гэж үзнэ.
- 7.5. If the Bidder decides to receive the commodity without using the Exchange's authorized logistics provider, the delivery shall be deemed completed upon loading.

Агуулахын баримт, хадгалалт

Warehouse Documentation, Storage

- 7.6. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, ачилт хийж дуусах хүртэл чанар, тоо хэмжээ, аюулгүй байдлыг хариуцна.
- 7.6. The authorized warehouse or terminal shall be responsible for the quality, quantity, and safety of the commodity from the time of receipt until the completion of loading.
- 7.7. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хадгалахдаа үндэсний холбогдох стандартад заасан хадгалалтын нөхцөлийг баримтлахаас гадна дараах нөхцөлийг бүрдүүлж ажиллана:
- 7.7. When storing the commodity, the authorized warehouse or terminal shall comply with relevant national storage standards and meet the following conditions:
- 7.7.1. камерын хяналтын системийг бүрдүүлсэн байх;
- 7.7.1. Be equipped with a camera surveillance system;
- 7.7.2. бүтээгдэхүүний овоолгын нэршлийн самбартай байх.
- 7.7.2. Have signage indicating the name of each commodity pile.
- 7.8. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь Биржээр арилжих, арилжсан бүтээгдэхүүнийг хүлээн авч “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам”-ын Хавсралт 3 /цаашид “агуулахын баримт” гэх/-г үйлдэн Биржид ирүүлнэ.
- 7.8. The authorized warehouse or terminal must issue the Annex 3 (hereinafter referred to as the "Warehouse document") of the "Regulation on Exchange Trading of Mineral Commodities", and submit it to the Exchange after receiving the commodities which will be traded, or traded through the Exchange.
- 7.9. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь итгэмжлэгдсэн лабораториор дээж авхуулах, шинжилгээ хийлгэх үйл ажиллагаанд хамтарч ажиллана. Худалдагч, эсхүл брокер нь шинжилгээний дүнг Биржид ирүүлнэ.

Зэсийн баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
Regulation For Establishing And Implementing Standard Of The
Copper Concentrate Trading Agreement

- 7.9. The authorized warehouse or terminal shall cooperate in the process of sampling and testing by an authorized laboratory. The seller or the broker shall submit the test results to the Exchange.
- 7.10. Худалдагч нь худалдан авагчтай байгуулсан гэрээний дагуу бүтээгдэхүүний төлбөрийг хүлээн авсан тухай баримтыг Биржид ирүүлснээр Бирж бүтээгдэхүүнийг хүлээн авах мэдэгдлийг худалдан авагч, эсхүл брокер болон итгэмжлэгдсэн агуулах, терминалд хүргүүлнэ.
- 7.10. Upon receipt by the Exchange of the receipt of payment for the commodity from the seller, based on the agreement made with the Bidder, the Exchange shall send the acceptance notice of the commodity to the Bidder or broker and the authorized warehouse or terminal.
- 7.11. Худалдагч нь агуулах, терминалаас ачилт хийхээс ажлын 3 хоногийн өмнө энэ талаар итгэмжлэгдсэн агуулах, терминалд мэдэгдэж, бүтээгдэхүүнийг хүлээн авах этгээдийн биеийн байцаалт, чингэлэг, тээврийн хэрэгсэл болон бүтээгдэхүүн хүлээн авах мэдэгдлийн талаар мэдээллийг урьдчилан итгэмжлэгдсэн агуулах, терминалд хүргүүлнэ.
- 7.11. The seller shall notify the authorized warehouse or terminal at least 3 business days prior to loading from the warehouse or terminal, and shall submit in advance the recipient's identification information, container and transport vehicle details, and the commodity acceptance notice to the authorized warehouse or terminal.
- 7.12. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь гэрээний дагуу нийлүүлэх бүтээгдэхүүний ачилтыг хийн худалдан авагчид хүлээлгэн өгч акт үйлдэн, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнгийн хамт Биржид ирүүлнэ.
- 7.12. The authorized warehouse or terminal shall carry out the loading of the commodities to be delivered under the agreement, hand them over to the Bidder, issue a delivery act, and submit it to the Exchange along with the authorized laboratory's test results.
- 7.13. Спот гэрээгээр арилжаалах бүтээгдэхүүнийг арилжаа зохион байгуулагдах өдрөөс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулж, бүртгэсэн байна.
- 7.13. Commodities to be traded under a spot agreement shall be placed and registered in the authorized warehouse or terminal at least 5 business days before the scheduled trading date.
- 7.14. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, хүлээлгэн өгөх бүртгэлийг хөтлөх бөгөөд Бирж нь хяналт, шалгалтын зорилгоор бүртгэл, агуулахын баримтыг тухай бүр шалгах эрхтэй байна.
- 7.14. The authorized warehouse or terminal shall maintain records of commodity receipt and delivery. The Exchange shall inspect such records and warehouse documents as part of its oversight and inspection duties.
- 7.15. Агуулахын баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн итгэмжлэгдсэн агуулах, терминал хариуцна.
- 7.15. The accuracy of the warehouse document is the responsibility of the authorized warehouse or terminal that issued it.

Чанарын хяналт

Quality Control

- 7.16. Худалдагч нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулсан бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийлгэх гэрээг Биржийн итгэмжлэгдсэн лабораторитой байгуулна.

- 7.16. The seller shall conclude an agreement with an Exchange-authorized laboratory to conduct quality testing on the commodities placed in the authorized warehouse or terminal.
- 7.17. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд төрийн байгууллагын зүгээс хяналт тавих зорилгоор нийт шинжилгээний дээжийн 10-аас доошгүй хувьд Геологийн судалгаа, шинжилгээний төв шинжилгээ хийж дүгнэлт гаргана.
- 7.17. In order to ensure government entity oversight of the certified laboratory analysis, the Geological Center for Research and Analysis shall conduct analysis and issue a conclusion on no less than 10 percent of the total sample tests.
- 7.18. Итгэмжлэгдсэн лаборатори нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршсан бүтээгдэхүүнээс Монгол Улсын холбогдох стандартад заасан аргачлалын дагуу дээж авч шинжилгээ хийнэ.
- 7.18. The authorized laboratory shall take samples from the commodities stored in the authorized warehouse or terminal and perform tests in accordance with the methodology specified by the relevant Mongolian standards.
- 7.19. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг агуулах, терминалд хүлээн авах болон агуулахаас ачилт хийх үеийн жинг үнэн зөв тооцож, баталгаажуулна.
- 7.19. The authorized warehouse or terminal shall accurately calculate and certify the weight of the commodities upon receipt into storage and during loading for dispatch.
- 7.20. Итгэмжлэгдсэн лаборатори нь бүтээгдэхүүний чанарын шинжилгээг хийж дууссаны дараа шинжилгээний үр дүнгийн хуудасны эх хувийг агуулах, терминалд, хуулбар хувийг Бирж болон худалдагчид хүргүүлнэ.
- 7.20. Upon completion of the quality analysis, the authorized laboratory shall deliver the original of the test result sheet to the warehouse or terminal, and send copies to the Exchange and the seller.
- 7.21. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнгийн хуудаст дээжийн мэдээлэл, сорилт, шинжилгээг гүйцэтгэсэн стандарт, шинжилгээ хийсэн үзүүлэлт, зөвшөөрөгдөх хэмжээ, хэмжих нэгж, үр дүнг тусгасан байна.
- 7.21. The laboratory test result sheet shall include information about the sample, the testing standards applied, the tested parameters, allowable limits, units of measurement, and the results.
- 7.22. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг агуулах, терминалаас ачих үед итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнгийн хуудсыг худалдан авагчид хүлээлгэн өгнө.
- 7.22. When loading the commodities from the warehouse or terminal, the authorized warehouse or terminal shall hand over the test result sheet from the authorized laboratory to the Bidder.
- 7.23. Чанарын маргаанаас шалтгаалан агуулах, терминалаас ачилт хийгдээгүй тохиолдолд худалдан авагч нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд мэдэгдэн ачилтыг түр хойшлуулж болно. Энэ тохиолдолд худалдан авагч нь Биржээс бүтээгдэхүүн хүлээн авах мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор давтан шинжилгээ

Зэсийн баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
Regulation For Establishing And Implementing Standard Of The
Copper Concentrate Trading Agreement



хийлгэх хүсэлтийг Биржид гаргана. Давтан шинжилгээ хийлгэх хүсэлтэд агуулах, терминалын нэр, бүтээгдэхүүний байршил, тоо хэмжээ, чанарын үзүүлэлт, холбоо барих хаяг болон шаардлагатай бусад мэдээллийг тусгаж, албан ёсны тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Давтан шинжилгээг худалдагч, худалдан авагчийн тохиролцож сонгосон Биржийн итгэмжилсэн шинжилгээний лаборатори гүйцэтгэх бөгөөд давтан шинжилгээний үр дүнгээс хамаарч төлбөрийг худалдан авагч, эсхүл худалдагч хариуцна.

- 7.23. In the event that loading from the warehouse or terminal is delayed due to a quality dispute, the bidder may notify the authorized warehouse or terminal to temporarily postpone the loading. In this case, the bidder shall submit a request for re-testing to the Exchange within 3 working days from the date of receiving the product receipt notice from the Exchange. The request for re-testing must include the name of the warehouse or terminal, location of the commodity, quantity, quality indicators, contact information, and other required details, and must be officially stamped and signed. The re-testing shall be conducted by an Exchange-authorized testing laboratory mutually selected by the seller and the bidder. Depending on the outcome of the re-test, the cost shall be borne by either the bidder or the seller.
- 7.24. Худалдан авагч нь заасан хугацаанд тогтоосон журмын дагуу давтан шинжилгээ хийлгэх хүсэлт гаргаагүй тохиолдолд агуулах, терминалаас ачсан бүтээгдэхүүний чанарыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.
- 7.24. If the bidder does not submit a re-testing request within the specified timeframe according to the established regulation, the quality of the commodity loaded from the warehouse or terminal shall be deemed as accepted.
- 7.25. Давтан шинжилгээний дүн болон анхдагч шинжилгээний үр дүн нь Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газраас баталсан холбогдох стандартаар тогтоосон стандарт хазайлтын хүрээнд багтах тохиолдолд шинжилгээний чанар хангалт шаардлага хангасан гэж үзнэ.
- 7.25. If the results of the re-test and the initial test fall within the acceptable deviation range defined by the relevant standards approved by the Mongolian Agency for Standard Metrology, the quality test shall be considered satisfactory.
- 7.26. Давтан шинжилгээний дүн болон анхдагч шинжилгээний үр дүн нь зөрүүтэй бөгөөд уг зөрүү нь стандарт хазайлтын хүрээнээс илүү гарсан тохиолдолд худалдагч болон худалдан авагч талуудын хооронд байгуулсан экспортын гэрээ буюу худалдах, худалдан авах гэрээгээр зохицуулна.
- 7.26. If the results of the re-test and the initial test differ and the deviation exceeds the standard tolerance range, the matter shall be resolved according to the export agreement or the sales and purchase agreement concluded between the seller and the bidder.

Найм.Бусад **Eight. Miscellaneous**

- 8.1. Арилжааны гэрээ болон энэ журамд заасан үүргийг талууд зөрчсөн тохиолдолд холбогдох хууль, журамд заасны дагуу хариуцлага ногдуулна.

Зэсийн баяжмалын гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх журам
Regulation For Establishing And Implementing Standard Of The
Copper Concentrate Trading Agreement



- 8.1. If either party breaches the obligations set out in the trading agreement or this regulation, liability shall be imposed in accordance with applicable laws and regulations.
- 8.2. Худалдан авагч нь өөрийн буруугаас гэрээгээр тогтоосон хугацаанд бүтээгдэхүүнийг хүлээн аваагүй тохиолдолд агуулах, терминалын төлбөрийг төлөх бөгөөд агуулахын төлбөрийг дараах байдлаар тооцно:
- 8.2. If the bidder fails to receive the commodity within the period specified in the agreement due to their own fault, they must pay the warehouse or terminal fees. These fees shall be calculated as follows:
- 8.2.1. агуулах терминалын төлбөрийг тухайн агуулах, терминалын худалдагчтай байгуулсан гэрээнд тусгагдах нөхцөлөөр;
- 8.2.1. Based on the terms specified in the agreement concluded between the respective warehouse or terminal and the seller;
- 8.2.2. худалдан авагч бүтээгдэхүүнийг хугацаа хожимдуулан хүлээн авснаас хойш тухайн агуулах, терминалын нэхэмжлэхийн дүнгээр.
- 8.2.2. Based on the invoice amount issued by the respective warehouse or terminal after the bidder has delayed the receipt of the commodity.
- 8.3. Итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулсан бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийх үйлчилгээний төлбөрийг худалдагч хариуцна.
- 8.3. The cost of quality inspection of the commodity stored in the authorized warehouse or terminal shall be borne by the seller.
- 8.4. Энэхүү журмын хэрэгжилтэд Бирж хяналт тавина.
- 8.4. The implementation of this regulation shall be monitored by the Exchange.

---oOo---